



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр


Дугаар 282

Улаанбаатар хот

“Сэндли ББСБ” ХХК-д “Гэгээн алтан од ББСБ” ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрч, “Гэгээн алтан од ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Компанийн тухай хуулийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3, Хорооны 2019 оны 370 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 7.2.1, 7.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХХК-д “Гэгээн алтан од ББСБ” ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрсүгэй.
2. “Гэгээн алтан од ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Сэндли ББСБ” ХХК /Д.Одгэрэл/-д үүрэг болгосугай.
4. “Гэгээн алтан од ББСБ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

